

ХАСБАНК ХК
Сонирхлын зөрчилтэй хэлцэл баталсан талаарх мэдээлэл

Тухай бүр мэдээлэх мэдээлэл /маягт 3/	
Тайлагнах хугацаа	2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Нэр: ХасБанк ХК УБГД: 000239852 РД: 2578697 Үнэт цаасны код: MN00ХАС05687 Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72 Утас: 75771888 И-майл: info@xacbank.mn Вэбсайт: www.xacbank.mn
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000 ширхэг энгийн хувьцаа
Тухай бүр мэдээлэх мэдээллийг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Ц.Алтантуяа, ТУЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн Хянасан: Н.Мөнхцэлмэг, Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл баталсан талаарх мэдээлэл	
<p>ХасБанк ХК (“Банк”)-ийн ТУЗ-ийн 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн R-2023-70 тоот шийдвэрээр, Банкны ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны зөвлөмжийн дагуу, Банкны эрх бүхий албан тушаалтан болон банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээдүүдийн нийт 70,500,000 (далан сая таван зуун мянга) төгрөгийн 3 (гурав) хэлцлийг батамжилсан болно. Эдгээр бүх хэлцэл нь Банкны тухай хуулийн 17.9-д заасан шаардлага буюу банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд олгогдсон, гуравдагч этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлгүй байх шаардлагыг хангасан болно.</p>	

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Н.Мөнхцэлмэг

Албан тушаал: Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

Огноо: 2023 он 10 сар 20 өдөр



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 23 оны .9. сарын 28. өдөр

№ R-2023-70

Улаанбаатар хот

Холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй
этгээдтэй хийсэн хэлцлийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, ХасБанк (“Банк”)-ны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-48 дугаар тогтоолоор батлагдсан Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг болон ТУЗ-ийн 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд, гарсан шийдвэрийг тус тус үндэслэн:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо (“ЭУХ”) 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаараа хэлэлцээд, энэхүү тогтоолын хавсралтад заасан холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн тодорхой хэлцлүүд (“Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүд”)-ийг батлах зөвлөмж ТУЗ-д хүргүүлсэн болохыг;
2. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүд нь аливаа хөнгөлөлттэй нөхцөлгүй, банкны өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд харилцагчдад санал болгож буй нөхцөлөөс илүү давуу тал олгоогүй болохыг ЭУХ тодорхойлсон болохыг; мөн
3. ТУЗ нь ЭУХ-ны өгсөн зөвлөмжийн дагуу Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг батламжлахыг дэмжсэн болохыг тус тус дурдав.

ТОГТООХ нь:

1. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ